



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 07 сарын 10 өдөр

Дугаар А/128

Улаанбаатар хот

Аймгийн заан цол олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Үндэсний Их баяр наадмын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тулгар Төрийн 2233, Их Монгол Улсын 818, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 113, Ардын хувьсгалын 103 жилийн ой, Багахангай дүүрэг үүсэн байгуулагдсаны 35 жилийн ойн хүрээнд үндэсний бөхийн цол олгох 128 бөхийн барилдаанд 6 давж үзүүрлэсэн Төв аймгийн Эрдэнэсант сумын харьяат Дүнжингарав дэвжээний бөх, Аймгийн харцага (цолтой) Б.Ганзолбоо-д “АЙМГИЙН ЗААН” цол олгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД